



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/128

Номгон

Малын халдварт өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, "Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Аймгийн хэмжээнд дархлаажуулалтын ажлыг хийснээс хойш 28 хоногийн хугацаанд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг тухайн сууриас хүнсний зориулалтаар гаргаж борлуулан нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

3. Дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

624010245